



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ГАДААД СУВГИЙН ТАЙЛАН

2024

1. ТАНИЛЦУУЛГА

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, тус хорооны 2021 оны 24 тоот тогтоолоор батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 5.5-д заасны дагуу өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгийн талаарх мэдээллийг тус хорооноос Оюуны өмчийн газартай хамтран баталсан маягтын дагуу ирүүлж, бүртгүүлэх ба албан ёсны эрхийн хугацаа дуусаж, сунгасан бол тухай бүр шинэчлэн бүртгүүлэх үүрэгтэй байдаг.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 6.2.1-т заасны дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн албан ёсны цахим хуудсаар “Үйлчилгээний нэр, төрөл, багц, үнэ тариф, сувгийн жагсаалт, суваг тус бүрийн товч мэдээлэл”-ийг байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэгтэй байдаг.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгийг бүртгэх ажлыг 2020 оноос эхлэн зохион байгуулж, “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн гадаад сувгуудыг бүртгэсэн тухай” дэлгэрэнгүй тайлан мэдээ гаргаж, цахим хуудсаараа мэдээлж ирсэн.

2. ГАДААД СУВАГ БҮРТГЭСЭН ТУХАЙ

Өнөөдөр Монгол Улсад Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 30 үйлчилгээ эрхлэгч байгаа ба үүнээс Монгол Улсад хамрах хүрээтэй-6, Улаанбаатар хотод хамрах хүрээтэй-7, орон нутгийн хамрах хүрээтэй-17 үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ жилийн тайланд 28 үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийн мэдээллийг багтаасан бөгөөд судалгаанд хамрагдаагүй 2 үйлчилгээ эрхлэгч нь гадаад суваг дахин дамжуулдаггүй үйлчилгээ эрхлэгчид юм.

Түүнчлэн гадаад сувгийн бүртгэл ирүүлсэн ОСДҮЭ-дийн тоонд өөрчлөлт ороогүй ч үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалтад өөрчлөлт орсон буюу үйлчилгээ эрхлэгч Халиун кабель ХХК өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлөө цуцлуулж, энэ жилийн гадаад сувгийн бүртгэлээс хасагдсан бол Мэргэшир-Од ХХК нээлттэй сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл авч маягтын дагуу гадаад сувгийн мэдээллээ ирүүлэн, энэ жилийн гадаад сувгийн бүртгэлд өөрийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийг бүртгүүлсэн байна.

Тус хорооноос Оюуны өмчийн газартай хамтран баталсан гадаад сувгийн бүртгэлийн маягтын дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн гадаад сувгийн дэлгэрэнгүй мэдээллээс харахад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр 32 орны нийт 285, давхардсан тоогоор нийт 760 гадаад суваг дахин дамжиж байна.

Гадаад сувгийн 2024 оны бүртгэлийн тайланд 285 гадаад суваг бүртгэгдсэн нь 2023 оныхтой харьцуулахад 2.4%-иар өсөж 7 сувгаар нэмэгдсэн байна. Үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж буй гадаад сувгийн харьяалагдах улсын хувьд тоонд өөрчлөлт ороогүй ч 3 улсын суваг хасагдаж, өөр 3 улсын суваг шинээр нэмэгдэж

нэрсийн жагсаалтад өөрчлөлт орсон байна. Мөн Гадаад сувгийн 2023 оны бүртгэлийн тайланд давхардсан тоогоор нийт 752 суваг бүртгэгдэж байсан бол 2024 оны бүртгэлийн тайланд 156 суваг хасагдаж, 164 суваг нэмэгдэж бүртгэгдсэнээр давхардсан тоогоор нийт 760 суваг ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байна. Үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгийн тоо их хэмжээгээр хасагдаж, нэмэгдсэн нь гадаад сувгийн гэрээний хугацаа дуусаж, шинэчлэн байгуулсантай холбоотой байна. Эдгээр 760 гадаадын телевизийн сувгаас 348 нь ОСДҮЭ-ийн үндсэн багцаар дахин дамжиж байгаа ба нийт сувагт эзлэх хувь нь 46% байна. Үлдсэн 412 гадаадын телевизийн суваг нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн нэмэлт багцаар дахин дамжиж байгаа ба нийт сувгийн 54%-ийг эзэлж байна.

Хүснэгт-1. Судалгаанд хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний нэр	Гадаад Сувгийн тоо
1	Юнивишн ХХК	Univision	84
2	Скаймедиа корпораци ХХК	Skymedia	60
3	ДДэш ТВ ХХК	Ddish	51
4	Эн Би Си ХХК	MNBC	50
5	ЖСММ БГБХ Нөхөрлөл	ЖСММ КаТВ	50
6	Дөрвөн шарга ХХК	Дөрвөн шарга КаТВ	48
7	Хаан Алтай Ховд ХХК	Хаан Алтай Ховд КаТВ	40
8	Шинэ сансар кабель ХХК	Beyond Media	33
9	Монголын цахилгаан холбоо ХК	National КаТВ	33
10	Монголсат нэтворкс ХХК	MongolSat	29
11	Мобинет ХХК	VOO	28
12	Талст эрчим ХХК	Талст КаТВ	27
13	Сансар Дижитал ХХК	Хөдөлгөөнт Телевиз	23
14	Цацраг трейд ХХК	Цацраг трэйд КаТВ	22
15	Оптимум нэтворк ХХК	Оптимум КаТВ	20
16	Агаарын суваг ХХК	Агаарын суваг КаТВ	19
17	Мэргэшир-Од ХХК	Мэргэшир-Од КаТВ	16
18	Дархан ширхэнцэг ХХК	Дархан ширхэнцэг КаТВ	15
19	Өвөр даваат ХХК	Өндөр Мандал КаТВ	14
20	Эм Эм Ди Эс ХХК	Эм Эм Ди Эс КаТВ	13
21	Ди Би Эс Си ХХК	Ди Би Эс КаТВ	13
22	Мөнх саран чулуу ХХК	Солонго КаТВ	13
23	Гал саятан ХХК	Стар КаТВ	13
24	Мандал ширхэнцэг ЗГБХН	Ширхэнцэг КаТВ	11
25	Лха хөх тэнгэр ХХК	Лха КаТВ	10
26	Би Ти Жи ХХК	Би Ти Жи КаТВ	10
27	Наран гүрт ХХК	ТОД caTV	9
28	Орхон системс ХХК	Орхон системс КаТВ	6

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь DVB-T2 технологиор үйл ажиллагаа эрхэлж байгаа ба тэдний сүлжээгээр дахин дамжиж

байгаа гадаадын телевизийн суваг давхардсан тоогоор 442 байна. Энэ нь үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа нийт сувгийн 58%-ийг эзэлж байгаа бол бусад (IPTV, OTT, DVB-C2, DVB-S2) технологиор ОСДҮ эрхэлж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр давхардсан тоогоор нийт 318 гадаадын суваг дахин дамжиж байгаа нь нийт сувгийн 42%-тай тэнцэж байна.



Утасгүй сүлжээний технологи буюу агаараар ОСДҮЭ-ийн сүлжээгээр давхардсан тоогоор **442** гадаад суваг дахин дамжиж байгаа ба нийт гадаад сувагт эзлэх хувь нь **58%**

Кабелиар ОСДҮЭ-ийн сүлжээгээр давхардсан тоогоор **66** гадаад суваг дахин дамжиж байгаа ба нийт гадаад сувагт эзлэх хувь нь **8%**

Хиймэл дагуулаар ОСДҮЭ-ийн сүлжээгээр давхардсан тоогоор **80** гадаад суваг дахин дамжиж байгаа ба нийт гадаад сувагт эзлэх хувь нь **9.8%**

Интернэт протокол (IPTV) ашиглан ОСДҮЭ-ийн сүлжээгээр давхардсан тоогоор **144** гадаад суваг дахин дамжиж байгаа ба нийт гадаад сувагт эзлэх хувь нь **19%**

Интернэт протокол (OTT) ашиглан ОСДҮЭ-ийн сүлжээгээр давхардсан тоогоор **28** гадаад суваг дахин дамжиж байгаа ба нийт гадаад сувагт эзлэх хувь нь **4.6%**

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгийг ямар дүрсийн форматаар хэрэглэгчдэд хүрч байгаа талаар судалж үзэхэд SD суваг нь 599 байсан бол үлдсэн 161 суваг нь HD форматаар хэрэглэгчдэд хүрч байна. Үйлчилгээ эрхлэгчдийн 3 нь 100% HD форматаар хэрэглэгчдэд гадаадын телевизийн сувгийг хүргэж байгаа бол 14 үйлчилгээ эрхлэгч нь 100% SD форматаар гадаадын телевизийн сувгийг хэрэглэгчдэд хүргэж байна. Бусад 11 үйлчилгээ эрхлэгч нь өөрийн олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгийг HD болон SD форматаар дахин дамжуулж байна.


Хамгийн их HD форматаар гадаад суваг дахин дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгч бол Юнивишн ХХК бөгөөд нийт 84 сувгаас 51 нь HD форматаар дахин дамжуулж байна. Харин хамгийн их SD форматаар гадаад суваг дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгч бол Эн Би Си ХХК болон ЖСММ БГБХ Нөхөрлөл бөгөөд 50 сувгийг SD форматаар дахин дамжуулж байна.

Технологийн онцлогоос шалтгаалан үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн ОСДҮ-ний сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгийг HD форматаар эсвэл SD форматаар дамжуулж байна. ОСДҮЭ-ийн сүлжээгээр дамжиж байгаа гадаадын 599 SD сувгаас 431 буюу 72% нь DVB-T2, DVB-S2 технологийг ашиглаж байгаа үйлчилгээ эрхлэгч байна. Эндээс харахад давтамж ашиглан хэрэглэгчдэд ОСДҮ-г хүргэж байгаа (DVB-T2, DVB-S2 технологи) үйлчилгээ эрхлэгчид нь зурвасын өргөнд хязгаарлагддаг тул өндөр багтаамжтай цөөн HD суваг дамжуулахаас илүү бага багтаамжтай олон SD суваг дамжуулахыг илүүд үзэж байна.

Хүснэгт-2. Үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгийг дүрсийн форматаар нь авч үзвэл

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Гадаад сувгийн тоо	Сувгийн формат	
			SD	HD
Улаанбаатар				
1	Шинэ сансар кабель ХХК	33	25	8
2	Монголын цахилгаан холбоо ХК	33	31	2
3	Сансар Дижитал ХХК	23	12	11
4	Эн Би Си ХХК	50	50	-
5	Талст эрчим ХХК	27	26	1
6	Оптимум нэтворк ХХК	20	19	1
7	Юнивишн ХХК	84	33	51
8	Скаймедиа корпораци ХХК	60	43	17
9	ДДэш ТВ ХХК	51	45	6
10	Монголсат нэтворкс ХХК	29	29	-
11	Мобинет ХХК	28	-	28
Орон нутаг				
1	Эм Эм Ди Эс ХХК	13	13	-
2	ЖСММ БГБХ Нөхөрлөл	50	50	-
3	Ди Би Эс Си ХХК	13	13	-
4	Лха хөх тэнгэр ХХК	10	10	-
5	Мөнх саран чулуу ХХК	13	13	-
6	Мэргэшир-Од ХХК	16	6	10
7	Цацраг трейд ХХК	22	21	1
8	Өвөр даваат ХХК	14	14	-
9	Агаарын суваг ХХК	19	19	-
10	Дархан ширхэнцэг ХХК	15	9	6
11	Орхон системс ХХК	6	6	-
12	Гал саятан ХХК	13	13	-
13	Мандал ширхэнцэг ЗГБХН	11	11	-
14	Би Ти Жи ХХК	10	-	10
15	Дөрвөн шарга ХХК	48	48	-
16	Хаан Алтай Ховд ХХК	40	40	-
17	Наран гүрт ХХК	9	-	9
Нийт		760	599	161


График-1. Үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгийг дүрсийн форматаар нь авч үзэн хувиар илэрхийлэв.



3.ОСДҮЭ-ИЙН СҮЛЖЭЭГЭЭР ДАХИН ДАМЖИЖ БАЙГАА ГАДААД СУВАГ

Монгол Улсад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 28 үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр 32 улсын давхардсан тоогоор нийт 760 гадаад суваг дахин дамжиж байгаа бөгөөд газар зүйн бүсээр нь авч үзэхэд Ази тивийн телевизийн суваг 497 байгаа нь нийт гадаадын сувгийн 65%-ийг эзэлж байна. Үүнээс ОХУ-ын телевизийн суваг хамгийн их буюу 277 байгаа нь нийт Ази тивийн телевизийн сувгуудын 56%-тай тэнцэж байна. Харин Австрали тивийн телевизийн суваг нь 11 байгаа нь нийт сувгийн хамгийн бага буюу 1.4% байна.

График-2. Гадаад сувгийг газар зүйн байршлаар авч үзэхэд



Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн хувьд: 11 үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр 29 улсын давхардсан тоогоор 438 гадаадын суваг дахин дамжиж байна.

Гадаад сувгийн 2023 оны дэлгэрэнгүй тайланд Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр 429 гадаадын телевизийн суваг дахин дамжиж байсан ба үүнээс 75 суваг хасагдаж, 84 суваг нэмэгдсэнээр энэ оны гадаад сувгийн дэлгэрэнгүй тайлан мэдээнд 438 суваг бүртгэгдсэн байна. Эдгээр 438 гадаад сувгаас ОХУ-ын 144 суваг байгаа нь хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дахин дамжиж байгаа нийт гадаад сувагт эзлэх хувь нь 32.8% байна. Харин Украин, Люксембург, Унгар, Турк зэрэг улсын телевизийн суваг 1 байгаа нь нийт сувгийн 0.1% буюу хамгийн бага хувийг эзэлж байна.

Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдээс хамгийн их гадаадын телевизийн суваг дахин дамжуулж байгаа нь Юнивишн ХХК бөгөөд нийт 84 суваг дахин дамжуулж байгаа нь нийт сувгийн 19%-тай тэнцэж байна. Харин хамгийн бага гадаадын суваг дахин дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгч бол Талст эрчим ХХК бөгөөд нийт 27 суваг дамжуулж байгаа нь нийт сувгийн 6%-тай тэнцэж байна.


Хүснэгт-3: Улаанбаатар хотын ОСДҮЭ-н сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг улсаар нь харуулав.

№	НЭР	УЛААНБААТАР ХОТ											Тоо
		Шинэ сансар кабель ХХК	Монголын цахилгаан холбоо ХК	Сансар Дижитал ХХК	Эн Би Си ХХК	Оптимум нэтворк ХХК	Юнивишн ХХК	Скаймедиа корпораци ХХК	Ддэш ТВ ХХК	Монголсат нэтворкс ХХК	Мобинет ХХК	Талст эрчим ХХК	
1	ОХУ	11	22	7	22	6	16	20	7	15	4	14	144
2	АНУ		2	1	1		20	6	18	1	9	2	60
3	БНХАУ	11	3	5	2	4	4	7	3			2	41
4	Франц	1		2	3	2	4	5	3	4	2		26
5	Сингапур	1		1	1		9	4	4	1	2	1	24
6	Их Британи		1		4	1	6	5	3	1			21
7	БНСУ	2		2	2	2	3	3	2		1	1	18
8	Герман	1	1	1	1	1	4	1	2	1	1	1	15
9	Казахстан				3	1	3	1	4	1			13
10	Япон	1	1		1	1	2	2	1	1	1	1	12
11	Шинэ Зеланд									1	6		7
12	Швед		1	1								4	6
13	Англи				1		2	1	1		1		6
14	Катар	1		1	1		1	1			1		6
15	Болгар				3		1		1				5
16	Итали	1		1	1			1					4
17	Канад				1		1		1			1	4
18	Киргизстан	1					3						4
19	Нидерланд		2							1			3
20	Австрали			1			1	1					3
21	Словак				1		1		1				3
22	Испани	1			1			1					3
23	Хонконг	1						1					2
24	Чех						1			1			2
25	Араб					2							2
26	Турк				1								1
27	Украйн						1						1
28	Люксембург						1						1
29	Унгар									1			1
Нийт		33	33	23	50	20	84	60	51	29	28	27	438

Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдээс “Скаймедиа корпораци” ХХК, “Ддэш ТВ” ХХК, МЦХ ХК болон “Талст эрчим ХХК-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгууд тогтвортой, сувгийн тоонд өөрчлөлт ороогүй бол бусад 7 үйлчилгээ эрхлэгчийн дахин дамжуулж байгаа гадаад сувагт нэлээдгүй өөрчлөлт орсон. Хамгийн их сувгийн тоог цөөлсөн үйлчилгээ эрхлэгч нь Юнивишн ХХК бөгөөд 22 гадаадын телевизийн суваг хасагдаж 84 суваг дахин дамжуулж

байна. Харин хамгийн их суваг нэмсэн үйлчилгээ эрхлэгч нь “Мобинет” ХХК ба 10 суваг нэмэгдэж 28 суваг дахин дамжуулж байна.

График-3. Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийн тоог өмнөх онтой харьцуулж үзвэл



Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд: Орон нутгийн 17 үйлчилгээ эрхлэгчийн хувьд 24 улсын давхардсан тоогоор 322 гадаад суваг дахин дамжуулж байгаа бөгөөд ОХУ 133 телевизийн суваг дамжуулж байгаа нь хамгийн их буюу 41% байна. Үүнээс 33 сувгийг нь “Дөрвөн шарга” ХХК дамжуулж байгаа нь орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулж байгаа 133 ОХУ-ын сувгийн 28%-ийг эзэлж байгаа бол хамгийн бага буюу 1.5%-ийг “Өвөрдаваат” ХХК (2 суваг), “Мандал ширхэнцэг” ХХК (2 суваг) зэрэг үйлчилгээ эрхлэгчид тус тус эзэлж байна. Харин Чех, Украин, Афганистан, Пакистан, Шинэ Зеланд, Канад зэрэг улсын 1 телевизийн суваг байгаа нь хамгийн бага буюу 0.3%-ийг эзэлж байна.

Гадаад сувгийн 2023 оны дэлгэрэнгүй тайлан мэдээнд орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр 323 гадаад суваг бүртгэгдэж байсан бол 2024 онд үүнээс 81 суваг хасагдан 80 суваг нэмэгдэж, нийт 322 гадаадын суваг бүртгэгдсэн байна.

Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдээс хамгийн их гадаадын суваг дахин дамжуулж байгаа нь ЖСММ БГБХ Нөхөрлөл бөгөөд гадаадын 50 суваг дамжуулж байгаа нь нийт сувгийн 15.5%-тай тэнцэж байна. Харин хамгийн бага гадаадын суваг дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгч нь “Наран гүрт” ХХК бөгөөд гадаадын 9 суваг дамжуулж байгаа нь нийт сувгийн 2.7%-тай тэнцэж байна.


Хүснэгт-4: Орон нутгийн ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг улсаар нь харуулав.

№	НЭР	ОРОН НУТАГ																Тоо	
		Эм Ди Эс ХХК	Лха хөх тэнгэр ХХК	Агаарын суваг ХХК	Гал саятан ХХК	Дөрвөн шарга ХХК	Хаан Алтай Ховд ХХК	Би Ти Жи ХХК	Өвөр даваат ХХК	Цацраг трейд ХХК	Мандал ширхэнцэг ХХК	Орхон систем ХХК	Ди Би Эс Си ХХК	Мөнхсаран Чулуу ХХК	ЖСММ ХХК	Дархан ширхэнцэг ХХК	Мэргэшир-Од ХХК		Наран гүрт ХХК
1	ОХУ	4	8	8	8	33	17	3	2	7	2	5	3	4	16	6	4	3	133
2	БНХАУ	3	1			2	3	2	5	8	3		3	3	3	4	1		41
3	Казахстан			1			6		1	1			1	2	17				29
4	АНУ		1	1	4	3	2	1				1	1	2	6		2	1	25
5	Франц	1				1	1		2	1	2		2			1	1		12
6	БНСУ	1			1	1	1	1	1	1	1				1	1	1		11
7	Герман	1		2			1		1	1	1			1		1	1	1	11
8	Швед			4		2	2								3				11
9	Англи					3	1								4	1			9
10	Их Британи					1	2	1		1							1	1	7
11	Япон	1		1			1			1							1	1	6
12	Нидерланд			1		2	1												4
13	Турк									1			2					1	4
14	Энэтхэг						1										1	2	4
15	Катар	1		1													1		3
16	Итали								1		1								2
17	Испани								1		1								2
18	Хонконг							1					1						2
19	Шинэ Зеланд															1			1
20	Канад						1												1
21	Чех																1		1
22	Украйн													1					1
23	Афганистан							1											1
24	Пакистан	1																	1
Нийт		13	10	19	13	48	40	10	14	22	11	6	13	13	50	15	16	9	322

Орон нутгийн 17 үйлчилгээ эрхлэгч дотроос хамгийн их гадаад сувгийн тоонд өөрчлөлт орсон үйлчилгээ эрхлэгч нь “Цацраг трейд” ХХК байсан ба 5 суваг хасагдаж, 22 суваг дахин дамжуулж байна. Харин “Гал Саятан” ХХК, “Ди Би Эс Си” ХХК-ийн дамжуулж байгаа суваг хоёроор нэмэгдсэн байна.

Түүнчлэн гадаад сувгийн 2023 оны дэлгэрэнгүй тайлан мэдээнд “Халиун кабель” ХХК 9 гадаад суваг бүртгүүлж байсан бол тухайн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлөө цуцлуулсан, “Мэргэшир-Од” ХХК нь тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар авч 16 гадаад суваг шинээр бүртгүүлсэн байна.


График-4. Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийн тоог өмнөх онтой харьцуулж үзвэл



3.1. ГАДААД СУВГИЙН ХАРЬАЛАХ УЛС:


Гадаад сувгийн бүртгэлд хамрагдсан 28 үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийг харьяалах улсаар нь авч үзэхэд ОХУ-ын суваг хамгийн их буюу 277 байгаа нь нийт сувгийн 36.8%-тай тэнцэж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График-5. ОСДҮЭ-н сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд



Харин үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудаас хамгийн бага хувийг эзэлж байгаа Афганистан, Люксембург, Пакистан, Унгар зэрэг улсын телевизийн суваг 1 байна.

График-6: ОСДҮЭ-ийн сүлжээгээр хамгийн бага дамжиж байгаа гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд



Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад суваг бүрийн тухайд: ОХУ-ын суваг болох Первый канал нь хамгийн их буюу 21 ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байна. Үүнээс 12 нь Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр, орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр 9 нь дахин дамжиж байна. Харин 13 улсын 137 телевизийн суваг хамгийн бага буюу 1 ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байна.

Хүснэгт-5: ОСДҮЭ-ийн сүлжээгээр хамгийн их дамжиж байгаа гадаадын 10 телевизийн сувгийн мэдээллийг хүснэгтээр үзүүлэв.

№	Гадаад сувгийн нэр	Гадаад сувгийн харьяалагдах улс	Формат	Хүлээн авч буй эх үүсвэр	Сувгийн төрөлжилт	Хөтөлбөрийн хэл	Дахин дамжуулж буй ОСДҮЭ-ийн тоо
1	Первый канал	ОХУ	SD	Хиймэл дагуул	Олон талт хөтөлбөртэй	Орос	21
2	Airang	БНСУ	HD	HLS	Олон талт хөтөлбөртэй	Англи	19
3	Deutsche Welle	Герман	HD	SRT	Мэдээний	Герман/Англи	18
4	Карусель	ОХУ	SD	Measat 3	Хүүхдийн	Орос	18
5	НТВ	ОХУ	SD	Хиймэл дагуул	Олон талт хөтөлбөртэй	Орос	13
6	РЕН ТВ	ОХУ	SD	Хиймэл дагуул	Олон талт хөтөлбөртэй	Орос	13
7	TV5 Monde	Франц	SD	Asiasat	Олон талт хөтөлбөртэй	Франц	12
8	NHK World	Япон	SD	Хиймэл дагуул	Олон талт хөтөлбөртэй	Япон	10
9	Матч	ОХУ	SD	Хиймэл дагуул	Спорт	Орос	10
10	Fashion TV	Франц	HD	Хиймэл дагуул	Загвар	Англи	9

Хамгийн олон ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийн тухайд: "Первый канал" нь ОХУ-ын анхны телевизийн суваг бөгөөд 1995 оны 1-р сарын 24-нд "Оросын олон нийтийн телевиз" (ОРТ) нэртэйгээр байгуулагдаж, мөн оны 4-р сарын 1-ний өдөр өргөн нэвтрүүлгийн телевиз болсон. "Первый канал" гэдэг

нэрийг 2002 оны 9-р сарын 2-нд авсан бөгөөд Орос улсын хүн амын 99,8%-д хүрдэг ба 2009 оноос хойш тус суваг нь мэдээллийн тэргүүлэх эх сурвалж байсаар ирсэн.


“Первый канал” суваг нь 2003 оны 11-р сараас хойш стерео дуугаралттай системд хэсэгчлэн шилжсэн бөгөөд 2008 онд өөрийн гэсэн интернэт нэвтрүүлэгтэй болсон.

Тус телевизийн Олон улсын нэвтрүүлэг нь тухайн бүс нутгийнхаа цагийн бүсэд тохируулан олон улсын дөрвөн хувилбараар нэвтрүүлгээ дамжуулдаг бөгөөд Украин, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнууд, Балтын орнууд, Европ, Хойд ба Өмнөд Америк, Ази, Номхон далайн орнууд, Австрали зэрэг бүс нутгуудад олон улсын нэвтрүүлгээ хүргэж байна. Өнөөдөр “Первый канал” сувгийг Орос улсын хүн амын 82% нь бусад мэдээллийн эх сурвалжаас илүүд үздэг, дэлхийн өнцөг булан бүрээс үзэх боломжтой, 250 сая гаруй үзэгчтэй, дэлхийн хамгийн өргөн тархсан, найдвартай суваг болсон байна.

3.2. ГАДААД СУВГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛ:

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгийн хөтөлбөр нь ямар хэл дээр дамжиж байгаа талаар судлахад Орос хэл дээр дамжиж байгаа телевизийн сувгийн тоо нь хамгийн их буюу 315 байна. Энэ нь нийт сувгийн 41.45%-ийг эзэлж байна. Харин “Болгар болон Герман/Англи, Солонгос/Англи” гэсэн хосолсон хөтөлбөрийн хэлтэй гадаадын телевизийн сувгууд нь 2 байгаа нь нийт сувгийн хамгийн бага буюу 0.26%-ийг эзэлж байна.


График-7: ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгуудыг хэлний төрлөөр нь нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд



3.3. ГАДААД СУВГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ:

Монгол Улсад дахин дамжиж байгаа гадаад сувгийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд олон талт хөтөлбөртэй телевизийн суваг хамгийн их буюу 175 байгаа нь нийт сувгийн 23%-ийг эзэлж байна. Дээрх олон талт хөтөлбөртэй телевизийн 175 сувгаас 83 нь Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дахин дамжиж байгаа бол 92 суваг нь орон нутгийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дахин дамжиж байна. Харин аялал жуулчлал болон тел худалдааны чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэн дамжуулдаг гадаадын телевизүүд 2 байгаа нь хамгийн бага буюу нийт гадаад сувгийн 0.2%-тай тэнцэж байна.

График-8: Давхардсан тоогоор дамжуулж байгаа сувгийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд



3.4. ОСДҮЭ-ИЙН ГАДААД СУВГИЙН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ:


Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн сүлжээгээр дахин дамжиж байгаа 760 гадаадын телевизийн сувгаас 296 сувгийг гэрээний үндсэн дээр дахин дамжуулж байгаа бол үлдсэн 464 сувгийг гэрээгүй дамжуулж байна. Үйлчилгээ эрхлэгчийн 5 нь өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаадын телевизийн сувгийг 100% гэрээтэйгээр дамжуулж байгаа бол 4 үйлчилгээ эрхлэгч нь тодорхой хэмжээгээр гэрээ байгуулсан ч хангалтгүй байна. Бусад 19 үйлчилгээ эрхлэгч буюу Улаанбаатар хотын 2 болон орон нутгийн 17 үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаадын телевизийн сувагтай гэрээ хийлгүйгээр дахин дамжуулж байна. Гэрээ хийж, гэрээний үндсэн дээр дахин дамжуулж байгаа 296 суваг нь нийт сувгийн 39%-ийг эзэлж байна.



Хүснэгт-6: ОСДҮЭ-ийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаадын телевизийн сувгуудтай гэрээ байгуулсан эсэх мэдээлэл

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Гадаад сувгийн тоо	Гэрээтэй сувгийн тоо	Гэрээгүй сувгийн тоо
Улаанбаатар				
1	Шинэ сансар кабель ХХК	33	21	12
2	Монголын цахилгаан холбоо ХК	33	3	30
3	Сансар Дижитал ХХК	23	11	12
4	Эн Би Си ХХК	50	50	-
5	Талст эрчим ХХК	27	-	27
6	Оптимум нэтворк ХХК	20	-	20
7	Юнивишн ХХК	84	84	-
8	Скаймедиа корпораци ХХК	60	60	-
9	ДДэш ТВ ХХК	51	10	41
10	Монголсат нэтворкс ХХК	29	29	-
11	Мобинет ХХК	28	28	-
Орон нутаг				
1	Эм Эм Ди Эс ХХК	13	-	13
2	ЖСММ БГБХ Нөхөрлөл	50	-	50
3	Ди Би Эс Си ХХК	13	-	13
4	Лха хөх тэнгэр ХХК	10	-	10
5	Мөнх саран чулуу ХХК	13	-	13
6	Мэргэшир-Од ХХК	16	-	16
7	Цацраг трейд ХХК	22	-	22
8	Өвөр даваат ХХК	14	-	14
9	Агаарын суваг ХХК	19	-	19
10	Дархан ширхэнцэг ХХК	15	-	15
11	Орхон системс ХХК	6	-	6
12	Гал саятан ХХК	13	-	13
13	Мандал ширхэнцэг ЗГБХН	11	-	11
14	Би Ти Жи ХХК	10	-	10
15	Дөрвөн шарга ХХК	48	-	48
16	Хаан Алтай Ховд ХХК	40	-	40
17	Наран гүрт ХХК	9	-	9
Нийт		760	296	464

График-9. Гэрээтэй болон гэрээгүй гадаад сувгийн тоог хувиар илэрхийлвэл



Дүгнэлт

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжиж байгаа гадаад улсын телевизийн сувгуудын тайлангаас харахад нийт улсын тооны хувьд өөрчлөлт ороогүй ч телевизийн сувгуудын жагсаалтад өөрчлөлт орсон буюу 156 суваг хасагдаж 164 суваг нэмэгдсэн байна. Энэ талаар олон суваг дамжуулагч үйлчилгээ эрхлэгчдээс тодруулахад тухайн телевизийн сувгуудын гэрээний хугацаа, үнэ, зах зээлийн эрэлт буюу хэрэглэгчдийн тухайн сувгийг үзэх сонирхол зэрэг олон шалтгаантай талаар дурдсан байна.

Түүнчлэн Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжиж байгаа гадаад улсын телевизийн сувгуудын 599 нь SD буюу стандарт тодролтойгоор, 161 суваг нь HD буюу өндөр тодролтойгоор хэрэглэгчдэд хүрч байгаа бөгөөд SD сувгуудын дийлэнх хувийг DVBT-2 технологи ашигладаг үйлчилгээ эрхлэгчид эзэлж байна. Үүнээс үзвэл үйлчилгээ эрхлэгчид нь технологиос хамаарч сувгийн сигналыг SD эсвэл HD форматаар дамжуулж байгаа бөгөөд давтамжийн зурвасын өргөнд тохируулан аль болох олон суваг багтаахаар тооцож SD буюу стандарт тодролтой сигнал сонгох явдал ажиглагдаж байна. Зарим үйлчилгээ эрхлэгчдийн хувьд ялангуяа IPTV-ийн үйлчилгээ эрхлэгчид нь сигналын чанарыг чухалчилж HD буюу өндөр тодролтой сигналыг дамжуулж байна.

Гадаад сувгийн 2024 оны дэлгэрэнгүй тайланд хамрагдсан зарим үйлчилгээ эрхлэгчид өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувагт өөрчлөлт оруулахдаа Зохицуулах хороонд мэдэгдэж “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 5.5-д заасны дагуу өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгийн талаарх мэдээллийг тус хорооноос Оюуны өмчийн газартай хамтран баталсан маягтын дагуу ирүүлж, бүртгүүлэх ба албан ёсны эрхийн хугацаа дуусаж, сунгасан бол тухай бүр шинэчлэн бүртгүүлэх үүрэгтэй гэж заасныг анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 6.2.1-т заасны дагуу өөрийн албан ёсны цахим хуудсанд Үйлчилгээний нэр, төрөл, багц, үнэ тариф, сувгийн жагсаалт, суваг тус бүрийн товч мэдээллээс гадна өөрийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгийн мэдээллийг тухай бүр шинэчлэн мэдээлэх шаардлагатай байна.